



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/146

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтаас Жаргалтхаан сумын Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хавсралтаар баталсугай.


2. Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, цахим системийн худалдан авах төлөвлөгөөний хугацааны дагуу шуурхай зохион байгуулах, он дамжсан санхүүжилттэй төсөл, арга хэмжээг 2025 онд бүрэн дуусгаж хүлээлгэн өгөхөөр тендерийн баримт бичиг, ажил гүйцэтгэх гэрээнд тусгах, 2025 оны 05 дугаар сарын 15-ны дотор багтаан шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж худалдан авах ажиллагааг бүрэн дуусгах, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай гэрээ байгуулан хэрэгжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Жаргалтхаан сумын Засаг дарга (С.Ганбат)-д даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын дарга (Г.Лхагвахатан)-д, барилга угсралт, их засварын ажлын захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



231010608



نکات مهم

04
А/176
Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 02-ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Д/д	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2025 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЕЗ
		Эхлэх	Дуусах			
1	Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалт (Жаргалтхаан)	2025	2026	420,000.0	270,000.0	Жаргалтхаан сумын Засаг дарга
	Нийт дүн			420,000.0	270,000.0	